



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн 3 дугаар байр, Залуучуудын гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103

Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.03.13 № 1-6/1804

танай _____-ын № _____-т

**┌ ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ СТАНЦ ┐
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ О.ТӨМӨРХУЯГ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу танай газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийж дуусган, аудитын тайлан, төлбөрийн актыг хургуулж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Хавсралт:хуудастай



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

442507318



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2026/5/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn
Дорноговь аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
Утас:	70522734
Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
Утас:	70523020
Ахлах аудитор:	О.Нарангарав
	Цахим хаяг: narangaravo@audit.gov.mn
	М.Дүүрэнжаргал
	Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	6
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.03.13 № 1-6/303

танай _____-ны № _____-т

**ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ
СТАНЦ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
О.ТӨМӨРХУЯГ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газрын санхүүгийн үндсэн үзүүлэлт болох нийт орлого төлөвлөгөөнөөс 575.2 сая төгрөгөөр буюу 5.6 хувиар тасарч, нийт зардал 213.5 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар хэтэрсэн гүйцэтгэлтэй, нийт алдагдал 120.4 сая төгрөгөөр зорилтод төвшнөөс буурсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Захирлын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/29 дүгээр тушаалаар албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан боловч ажилтанд тухайн сарын үр дүнгийн урамшууллыг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ-ын захирлын 2022 оны А/141 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар зүйлийн 8.7.2-т “сахилгын шийтгэл ногдуулсан ажилтны тухайн сарын урамшуулал цалинг олгохгүй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

442505280

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	43,341,048.61	28,678,777.51
1.1.02	Дансны авлага	236,257,372.59	498,250,782.53
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	10,010,000.00	10,020,000.00
1.1.04	Бусад авлага	60,116,588.00	70,484,084.74
1.1.05	Бараа материал	1,116,941,890.61	1,225,068,669.36
1.1.06	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,425,199.25	9,525,933.16
1.1.07	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,479,092,099.06	1,842,028,247.30
1.2.01	Үндсэн хөрөнгө	77,205,849,831.29	76,397,417,876.88
1.2.02	Биет бус хөрөнгө	12,901,322.00	7,169,909.17
1.2.03	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	77,218,751,153.29	76,404,587,786.05
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	78,697,843,252.35	78,246,616,033.35
2.1.1.01	Дансны өглөг	850,430,445.33	1,170,357,000.00
2.1.1.02	Татварын өр	310,502,693.37	26,835,974.84
2.1.1.03	Урьдчилж орсон орлого	17,355,620.27	16,252,519.39
2.1.1.04	Бусад богино хугацаат өр төлбөр	830,390.18	755,012.00
2.1.1.05	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,179,119,149.15	1,214,200,506.23
2.1.2.01	Бусад урт хугацаат өр төлбөр	8,749,865,392.72	9,192,745,799.02
2.1.2.02	Урт хугацаат өр төлбөрийн дүн	8,749,865,392.72	9,192,745,799.02
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,928,984,541.87	10,406,946,305.25
2.3.01	Өмч: - төрийн	75,567,469,417.78	76,613,658,243.78
2.3.02	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	106,632,845.92	105,668,505.92
2.3.03	Хуримтлагдсан ашиг	(6,905,243,553.22)	(8,879,657,021.60)
2.3.03.1	Тайлангийн үеийн ашиг	(4,452,787,975.71)	(1,975,377,808.38)
2.3.03.2	Өмнөх үеийн ашиг	(2,452,455,577.51)	(6,904,279,213.22)
2.3.04	Эздийн өмчийн дүн	68,768,858,710.48	67,839,669,728.10
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	78,697,843,252.35	78,246,616,033.35

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	7,355,462,512.08	9,658,018,118.63
02	Борлуулалтын өртөг	9,138,370,125.69	10,900,883,152.70
03	Нийт ашиг(алдагдал)	(1,782,907,613.61)	(1,242,865,034.07)
04	Хүүний орлого	690,239.27	323,691.69
05	Бусад орлого	1,024,095,726.10	1,013,292,017.76
06	Орлогын дүн	1,024,785,965.37	1,013,615,709.45
07	Ерөнхий ба удирдлагын зардал	1,695,548,905.36	1,742,201,714.59
08	Санхүүгийн зардал	616,000.00	594,400.00
09	Бусад зардал	-	3,300,000.00
10	Зардлын дүн	1,696,164,905.36	1,746,096,114.59
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	1,900,000.00	-
12	Олз, гарзын дүн	1,900,000.00	-
13	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(2,452,386,553.60)	(1,975,345,439.21)
14	Орлогын татварын зардал	69,023.91	32,369.17
15	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,452,455,577.51)	(1,975,377,808.38)
16	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
17	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,452,455,577.51)	(1,975,377,808.38)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	75,567,469,417.78	106,632,845.92	(4,449,372,845.53)	71,224,729,418.17
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(3,415,130.18)	4417144353 ЕЮА (3,415,130.18)
03	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(2,452,455,577.51)	(2,452,455,577.51)
04	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	75,567,469,417.78	106,632,845.92	(6,905,243,553.22)	68,768,858,710.48
05	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	964,340.00	964,340.00
06	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(1,975,377,808.38)	(1,975,377,808.38)
07	Өмчид гарсан өөрчлөлт	1,046,188,826.00	-	-	1,046,188,826.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(964,340.00)	-	(964,340.00)
09	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	76,613,658,243.78	105,668,505.92	(8,879,657,021.60)	67,839,669,728.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,384,666,568.89	11,475,815,996.69
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,201,656,692.17	10,196,517,135.38
1.1.2	Татаас, санхүүжилтийн орлого	1,000,000,000.00	1,000,000,000.00
1.1.3	Бусад мөнгөн орлого	183,009,876.72	279,298,861.31
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,210,564,350.12	11,221,313,547.79
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,691,993,802.58	3,895,463,604.97
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,227,564,708.42	1,213,046,340.21
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,177,322,446.77	2,815,211,855.22
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	748,633,913.10	978,569,994.70
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	235,014,090.00	213,426,280.00
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	796,234,324.53	1,633,940,053.25
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн	3,676,836.00	6,934,450.00
1.2.8	Бусад мөнгөн зарлага	330,124,228.72	464,720,969.44
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	174,102,218.77	254,502,448.90
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,900,000.00	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,900,000.00	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	335,035,665.48	269,164,720.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	335,035,665.48	269,164,720.00

Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(333,135,665.48)	(269,164,720.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(159,033,446.71)	(14,662,271.10)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	202,374,495.32	43,341,048.61
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	43,341,048.61	28,678,777.51

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлтүүд	2025 оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт			
	а) Дулаан үйлдвэрлэлт - Гкал	69,660.00	66,870.00	2,790.00
	б) Ус хангамж - м3	338,630.00	342,100.00	(3,470.00)
	в)Ариутгах татуурга - м3	274,290.00	286,350.00	(12,060.00)
	Нийт орлого - төгрөг	10,337,756,530.00	9,762,542,919.00	575,213,611.00
	Үүнээс: Цэвэр борлуулалт	9,837,756,530.00	8,727,152,158.00	1,110,604,372.00
	а) Дулаан үйлдвэрлэлт	8,619,135,810.00	7,590,171,865.00	1,028,963,945.00
	б) Ус хангамж	738,738,140.00	726,393,583.00	12,344,557.00
	в)Ариутгах татуурга	479,882,580.00	410,586,710.00	69,295,870.00
	Бусад орлого /алданги торгуулийн засвар үйлчилгээний орлогууд/	500,000,000.00	1,035,390,761.00	(535,390,761.00)
3	Нийт зардал - төгрөг	12,433,478,810.00	12,646,979,267.29	(213,500,457.29)
3.1	Үүнээс: Удирдлагын зардал	303,071,100.00	309,693,959.35	(6,622,859.35)
4	Татварын өмнөх ашиг /алдагдал	(2,095,722,280.00)	(2,884,436,348.29)	788,714,068.29
5	Улсын төсвийн татаас		909,090,909.08	(909,090,909.08)
6	Цэвэр ашиг /алдагдал/	(2,095,722,280.00)	(1,975,345,439.21)	(120,376,840.79)
7	Төсвийн төлбөр	3,801,229,380.00	3,676,759,110.00	124,470,270.00
7.1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	-	-	-
7.2	Нэмэгдсэн өртгийн албан татвар	976,927,560.00	1,866,230,480.00	(889,302,920.00)
7.3	Ус ашигласны төлбөр	10,323,940.00	13,579,060.00	(3,255,120.00)
7.4	Газрын төлбөр	3,404,000.00	5,859,790.00	(2,455,790.00)
7.5	Агаарын бохирдлын төлбөр	3,143,600.00	2,971,330.00	172,270.00
7.6	Тээврийн хэрэгслийн татвар	720,430,000.00	720,430.00	719,709,570.00
7.7	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	1,483,589,600.00	1,213,046,340.00	270,543,260.00
7.8	Үл хөдлөх хөрөнгийн татвар	162,957,400.00	155,084,120.00	7,873,280.00
7.9	ХХОАТ	420,453,280.00	415,967,560.00	4,485,720.00
7.10	Бусад	20,000,000.00	3,300,000.00	16,700,000.00
8	Төрийн өмчийн ногдол ашиг			
9	Ажиллагсдын тоо - хүн	149	141	8
10	Нийт цалингийн сан - төгрөг	4,902,028,000.00	4,660,675,900.00	241,352,100.00
11	Нэг ажилтны сарын дундаж цалин	2,741,626.40	2,754,536.58	(12,910.19)
12	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	1.20	1.30	(0.09)
13	Хөрөнгө оруулалт - төгрөг	417,798,800.00	274,273,800.00	143,525,000.00
14	Нийт авлага	469,753,480.00	274,273,800.00	143,525,000.00
15	Нийт өглөг	550,000,000.00	578,754,867.27	(109,001,387.27)
15.1	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	-	10,406,946,305	(9,856,946,305.25)
15.2	Урт хугацаат өр төлбөрт	-	1,214,200,506.23	(1,214,200,506.23)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний үйл ажиллагаа

Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хэрэглэгчдийг нэгдсэн байдлаар дулааны эрчим хүч, ахуйн хэрэглээний цэвэр, халуун усаар найдвартай хангах, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хэрэглээнээс гарсан бохир усыг зайлуулах, цэвэрлэхтэй холбогдсон ажил, үйлчилгээ үзүүлэх бөгөөд дор дурдсан чиглэлтэй байна. Үүнд:

- Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ
- Ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ
- Цэвэр ус дамжуулах, түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ
- Орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ
- Ус дамжуулах төвийн ашиглалт, засвар үйлчилгээ
- Бохир усны цуглуулах болон гаргалгааны шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ
- Бохир усны татан зайлуулах, цэвэрлэх байгууламжийн шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ
- Ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт тохируулга хийх үйлчилгээ

Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зорилт нь “Замын-Үүдийн Дулааны станц”-ын туршилт, тохируулга, зүгшрүүлэлтийг хийж, орон нутгийн хүний нөөцийг бүрдүүлэх, чадавжуулах, Замын-Үүд сум болон Замын-Үүд чөлөөт бүсийн хэрэглэгчдийг 2 дугаар хэлхээний инженерийн шугам сүлжээнд холбож, “Замын-Үүд Дулааны станц”-ыг ашиглалтын хэвийн горимд оруулах, улмаар хэрэглэгчдийг нэгдсэн байдлаар дулааны эрчим хүч, ахуйн хэрэглээний халуун усаар найдвартай хангах, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад оршино.

“Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын зорилгоо “Байгальд ээлтэй дэвшилтэт технологиор ус, дулаан хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх” гэж тодорхойлсон байна.

Хэтийн зорилгоо “2021-2025 онд хүний хөгжлийг дээдэлсэн, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологид суурилсан ТӨҮГ болно” гэж тодорхойлсон байна.

3.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин

Шалгагдагч байгууллага нь дараах эрх зүйн орчны хүрээнд үндсэн үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд бусад хуульд бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлэхээр заасан бол тус хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа, зохион байгуулалт хяналтыг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд: *Хууль тогтоомж:*

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль

Тогтоол: - Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоолууд

- Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолууд
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолууд, чиглэлүүд, албан даалгаврууд

Бусад дүрэм, журам: - Засгийн газрын 2020 оны 123 дугаар тогтоолын хавсралт “Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын дүрэм

- Дулааны станц ТӨҮГ-ын захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан 2023-2024 оны хамтын гэрээ

- Замын-Үүдийн дулааны станц ТӨҮГ-ын 2022-2024 онд баримтлах хүний нөөцийн бодлогын баримт бичиг
- Мэргэжлийн мэдлэгийн шалгалт авах журам
- Ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрэм
- Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрүүд

“Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

“Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын дотоод аудит, хяналт шалгалтыг тус байгууллагын бүтцийн нэгж болох дотоод хяналтын алба гүйцэтгэдэг бөгөөд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Тухайлбал: тайлант онд худалдан авах ажиллагаа, худалдан авалт, байгууллагын өмч, хөрөнгийн бүртгэл, тооцоо ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт, бусад үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн холбогдох заавар зөвлөмжийг өгч, үр дүнг дүгнэн биелэлтийг хангуулан ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Замын-Үүдийн Дулааны” станц ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд Захирлын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр А/109 дугаар тушаалаар баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 451.2 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс санхүүгийн тайлангийн бүх дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	43,341.05	28,678.78	(14,662.27)	(33.83)
Авлага	306,383.96	578,754.87	272,370.91	88.90
Урьдчилгаа	12,425.20	9,525.93	(2,899.27)	(23.33)
Бараа материал	1,116,941.89	1,225,068.67	108,126.78	9.68
Үндсэн хөрөнгө	77,218,751.15	76,404,587.79	(814,163.37)	(1.05)
Нийт хөрөнгө	78,697,843.25	78,246,616.03	(451,227.22)	(0.57)
Өр төлбөр	9,928,984.54	10,406,946.31	477,961.76	4.81
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	68,768,858.71	67,839,669.73	(929,188.98)	(1.35)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	78,697,843.25	78,246,616.03	(451,227.22)	(0.57)

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 28.7 сая төгрөг болж, 14.7 сая төгрөгөөр буюу 33.8 хувиар буурсан нь төлөвлөгөөт үйл ажиллагааны орлого дутуу, авлагын нэмэгдсэн нь шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 578.7 сая төгрөг болж өмнөх оноос 272.4 сая төгрөгөөр буюу 88.9 хувиар өссөн нь Замын-Үүд сумын ЗДТГ-аас худалдан авах ажиллагааны санхүүжилтийг дутуу олгож, үлдэгдэл 172.9 сая төгрөгийн авлагыг бүртгэсэн нь нөлөөлсөн байна. Нийт авлагын 165.5 сая төгрөг нь насжилт өндөртэй, 195.0 сая төгрөг нь төсөвт байгууллагаас авах, 96.0 сая төгрөг нь ААН байгууллагаас, 37.6 сая төгрөг нь айл өрхөөс авах авлага, 74.6 сая төгрөг нь бусад авлага, 10.0 сая төгрөг нь ААНОАТ-ийн авлага байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 9.5 сая төгрөг болж 2.9 сая төгрөгөөр буурсан бөгөөд энэ нь түлш шатахууны худалдан авалтыг бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа дансанд бүртгэн авч хаадагтай холбоотой байна. Түлш шатахууны зардлын урьдчилгааны үлдэгдэл 8.5 сая төгрөг байна.

Бараа материал дансны үлдэгдэл 1,225.1 сая төгрөг болж 108.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь түүхий эдийн үлдэгдэл 151.1 сая төгрөгөөр, дуусаагүй үйлдвэрлэл 1.4 сая төгрөгөөр, хангамжийн материал 29.5 төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Нийт материалын үлдэгдэлд нүүрс, түлш шатахууны материал 800.9 сая төгрөг, зайлшгүй байх нөөц материал 36.5 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн материал 46.0 сая төгрөг, ХАБЭА материал 15.4 сая төгрөг, лабораторийн материал 31.5 сая төгрөг, барилга сантехникийн материал 87.9 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 76404.6 сая төгрөг болж, 814.2 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын холбогдох шийдвэрийн дагуу 327.4 сая төгрөгийн, захирлын тушаалаар 1,161.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр, өөрийн орлогоос 246.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, холбогдох шийдвэрийн дагуу 53.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлээс хассан, хуримтлагдсан элэгдэл 2,543.9 сая төгрөгийн өссөн зэрэг нөлөөлсөн байна. Нийт хөрөнгийн үлдэгдлийн 41,769.0 сая төгрөг буюу 55.1 хувийг барилга байгууламж, 32,589.1 сая төгрөг буюу 42.7 хувийг машин тоног төхөөрөмж, 2,039.2 сая төгрөг буюу 2.7 хувийг бусад хөрөнгө тус тус эзэлж байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10,406.9 сая төгрөг болж өмнө оноос 478.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үнэгүй нэмэгдсэн үндсэн хөрөнгийн цэвэр дүн 442.9 сая төгрөгийг хойшлогдсон орлого буюу урт хугацаат өр төлбөр бүртгэсэнтэй холбоотой байна. Нийт өр төлбөрийн 1,214.2 сая төгрөг нь богино хугацаат өр төлбөр бөгөөд 1,170.0 сая төгрөг нь нүүрсний татан авалтын, 26.8 сая төгрөг нь татварын байгууллагад төлөх, 17.4 сая төгрөг бусад өглөг тус тус байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 67,839.5 сая төгрөг болж, 929.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны гүйцэтгэлээр 1,975.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу ТӨБЗГ нь төрийн өмчит хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшинг ТӨБЗГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 16 оны өдрийн 720 дугаар тогтоолоор баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 10,337.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 12,433.5 сая төгрөгөөр, 2,095.7 сая төгрөгийн алдагдалтай байхаар тус тус баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 417.8 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд дараах үзүүлэлтийг тусгаж, баталсан байна. Үүнд, нийт орлого, зардал, ашиг, алдагдал, ажиллагсдын тоо, цалингийн сан, нэгж бүтээгдэхүүний өртөг, хөрөнгө оруулалтын зардал, нийт авлага, өглөг зэрэг болно.

Гүйцэтгэлээр 10,671.6 сая төгрөгийн орлоготой, 12,647.0 сая төгрөгийн зардалтай, 1,975.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого гүйцэтгэлээр 333.9 сая төгрөгөөр давсан нь 909.1 сая төгрөгийн татаас санхүүжилт авсан мөн бусад үйл ажиллагааны орлого 535.4 сая төгрөгөөр буюу худалдан авах ажиллагаагаар засвар үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой давж биелсэнтэй байна.

Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Дулаан хангамжийн орлого	8,619,135.8	7,590,171.9	1,028,963.9	88.1
Ус хангамж, ариутгах татуургын орлого	1,218,620.7	1,136,980.3	81,640.4	93.3
Татаас санхүүжилт	0.0	909,090.9	(909,090.9)	#DIV/0!
Бусад орлого	500,000.0	1,035,390.8	(535,390.8)	207.1
Нийт	10,337,756.5	10,671,633.8	(333,877.3)	103.2

Орлогын ангиллаар авч үзэхэд дулаан хангамжийн орлого 1,029.0 сая төгрөгөөр тасарсан нь шинэчилсэн тарифыг мөрөөдөөгүтэй холбоотой байна.

Ус хангамж, ариутгах татуургын орлого 81.6 сая төгрөгөөр тасарсан нь албан газар, байгууллага, хувь хүмүүс усны хэмнэлт хийсэнтэй холбоотой байна.

Нийт зардлыг 12,433.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 12,647.0 сая төгрөг буюу 1.7 хувийн зардлын хэтрэлтэй байна.

Хүснэгт 3. Зардлын үзүүлэлт

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
А	Б	1	4	5=3-4	
1	Түлш	2,046,784,470.00	1,845,869,013.92	200,915,456.08	
2	Шатахуун, шатах тослох материал	219,196,500.00	146,924,344.08	72,272,155.92	
3	Туслах материал	138,483,740.00	27,617,826.77	110,865,913.23	
4	Засвар үйлчилгээний зардал	40,000,000.00	26,390,577.16	13,609,422.84	
5	Сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж	168,932,000.00	138,308,437.18	30,623,562.82	
6	Урсгал засвар	322,469,570.00	312,000,943.80	10,468,626.20	
7	Захиалгат ажлын зардал	66,100,000.00	359,530,985.48	(293,430,985.48)	
8	Хангамжийн мат зардал/багаж, бүтээ/	53,193,510.00	56,733,763.49	(3,540,253.49)	
9	Үндсэн ба нэмэгдэл цалин, хөлс	4,459,202,340.00	4,415,997,413.10	43,204,926.90	
10	Нийгмийн даатгалын шимтгэл	646,584,340.00	619,408,964.60	27,175,375.40	
11	Цахилгаан	931,185,390.00	872,419,787.71	58,765,602.29	
12	Томиллолт	44,000,000.00	63,582,146.59	(19,582,146.59)	
13	Бичиг хэрэг	15,673,800.00	11,305,005.19	4,368,794.81	
14	Шуудан харилцаа холбооны зардал	38,596,000.00	32,075,087.51	6,520,912.49	
15	Хөдөлмөр хамгаалал	174,288,600.00	167,485,580.23	6,803,019.77	
16	Үндсэн хөрөнгийн элэгдэл	2,100,000,000.00	2,541,733,921.73	(441,733,921.73)	
17	Удирдлагын зардал	303,071,100.00	309,872,856.05	(6,801,756.05)	
18	Үл хөдлөх хөрөнгийн татвар	162,957,350.00	155,084,128.35	7,873,221.65	
19	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	720,434.29	279,565.71	
20	Газрын төлбөр	4,000,000.00	5,859,797.00	(1,859,797.00)	
21	Агаар бохирдлын зардал	3,134,100.00	-	3,134,100.00	
22	Зохицуулалтын зардал	24,750,000.00	33,350,920.00	(8,600,920.00)	
23	Даатгалын зардал	9,000,000.00	9,905,783.67	(905,783.67)	
24	Сургалтын зардал	15,990,000.00	19,385,521.82	(3,395,521.82)	
25	Гадны үйлчилгээний хөлс	51,620,000.00	50,299,515.22	1,320,484.78	
26	Түрээсийн зардал	39,600,000.00	66,114,101.76	(26,514,101.76)	

27	Байгаль орчин хамгаалах зардал	1,280,000.00	-	1,280,000.00
28	Болзошгүй эрсдэлийн зардал	70,000,000.00	45,956,802.25	24,043,197.75
29	Бусад зардал	18,278,000.00	17,730,833.45	547,166.55
30	Ажиллагсдын нийгмийн зардал	264,108,000.00	253,763,584.00	10,344,416.00
31	Бусад татвар хураамж	-	17,824,487.55	(17,824,487.55)
32	Банкны шимтгэл зардал	-	1,122,400.00	(1,122,400.00)
33	ББӨ	-	19,304,303.34	(19,304,303.34)
34	Торгууль	-	3,300,000.00	(3,300,000.00)
	Нийт зардал журналаар	12,433,478,810.00	12,646,979,267.29	(213,500,457.29)
	Үйл ажиллагааны ашиг, алдагдал	(2,095,722,280.00)	(1,975,345,439.21)	(120,376,840.79)
	ОАТ	-	32,369.17	(32,369.17)
	Нийт ашиг, алдагдал	(2,095,722,280.00)	(1,975,377,808.38)	(120,344,471.62)

Зардлын гүйцэтгэлээр 14 зардал батлагдсан төлөвлөгөөнөөс 847.9 сая төгрөгөөр хэтэрч, 20 зардал 634.4 сая төгрөгөөр хэмнэгдэж нийт дүнгээр 213.5 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Зардлын хэтрэлтэд тендерийн болон захиалгат ажилд ашиглагдсан бараа материалын зарцуулалт, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын нэмэгдэл зэрэг нь нөлөөлсөн байна. .

Тайлант оны хөрөнгө оруулалтыг 13 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд 417.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 8 нэр төрлийн бараа ажил үйлчилгээнд 274.3 сая төгрөгийг зарцуулан, гүйцэтгэл 65.7 хувьтай тайлагнагдсан байна.

Тайлант онд 1,975.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, төлөвлөснөөс 120.3 сая төгрөгөөр буурсан татаас санхүүжилт олгогдсон, бусад орлого нэмэгдсэн, зарим зардал хэмнэгдсэн зэрэг нөлөөлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Замын-Үүдийн Дулааны станц”-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ТӨҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн ил тод байдлыг хангах, хоорондын тооцоо нийлэх, хөрөнгө бүртгэж авах зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав, М.Дүүрэнжаргал нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

“Замын-Үүдийн Дулааны станц” нь 2025 оны санхүүгийн тайлангаа Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/23 дугаар албан бичгээр 2026 оны 02-р сарын 13-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн тайлангийн нийт зардал 10,834.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 108.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг 108.3 сая төгрөгөөс эрсдэлийн түвшинг дунд гэж үзэн 70 хувиар буюу 75.8 сая төгрөгөөр тооцсон болно. Аудитын явцад дахин хянаж тайлант материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд хөрөнгө зарцуулахтай холбоотой 1,270.8 сая төгрөгийн 56 тушаал шийдвэр гаргаснаас 15.0 сая төгрөгийн 1 шийдвэрийг хугацаа хоцроосон байна. Мөн 5.0 сая төгрөгөөс дээш 5,136.3 сая төгрөгийн 174 зарлагын гүйлгээнээс 607.8 сая төгрөгийн 30 гүйлгээг хугацаа хоцроосон байна. Мэдээлсэн болон хугацаа хоцролтын хувь 85.0-аас дээш тул зөрчилгүйгээр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан,

тайлагнаж ажилласан байна. Тайлант онд 3,329.1 сая төгрөгийн 45 төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсний 3,007.5 сая төгрөгийн 19 бараа, ажил, үйлчилгээ нь 20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт байна. Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан 19 худалдан авалтаас 118.1 сая төгрөгийн 2 ажил хийгдээгүй, 1 ажил буюу хүнсний материалын худалдан авах ажиллагааг 5 удаа зарласан боловч оролцогч орж ирээгүйгээс олон ААН, хувь хүнээс шууд гэрээгээр худалдан авч, 16 бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны эхний 9 сарын санхүүгийн тайлан, баримтад завсрын аудитыг хийн, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг буруу илэрхийлсэн байх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, бүрэн хөтлөөгүй байх, авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч болон бэлтгэн нийлүүлэгч этгээдтэй тооцоо нийлсэн нийлж, баталгаажуулаагүй байх, насжилттай авлагыг бууруулах арга хэмжээ зохион байгуулаагүй байх, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байх, үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байх зэрэг 8 горим сорилыг хэрэгжүүлж төлөвлөгөө хөтөлбөрийг батлуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийддэрийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	4.0	1	4.0	100%
Албан шаардлага	1	9.0	1	9.0	100%
Төлбөрийн акт	2	4.7	2	4.7	100%
Нийт дүн	4	17.7	4	17.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татсан асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6.3 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илрүүлснээс 0.2 сая төгрөгийн 1 алдааг залруулан, залруулагдаагүй 6.1 сая төгрөгийн 2 зөрчилд 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 5.7 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөв.

Аудитын явцад залруулсан алдаа:

1. Түлш шатах тослох материалын үлдэгдэлд -0.2 сая төгрөгийн материалын үлдэгдэл тайлагнагдсан алдааг аудитын явцад залруулав.

5.1. Төлбөрийн акт

1. Захирлын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/29 дүгээр тушаалаар станцын ээлжийн инженер Б.Аззаяад албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан боловч ажилтанд тухайн сарын үр дүнгийн 388,080 төгрөгийн урамшууллыг олгосон байна.

5.2. Зөвлөмж

1. Албан томилолттой холбоотой асуудал:

Илрүүлэлт: Албан томилолтоор ажилласан албан хаагчдын албан томилолтын хуудсанд томилолтоор ажиллах хоног хугацааг батлаагүй, томилолтыг хянуулж хаасан хугацаа журамд заасан хугацаанаас хэтэрсэн, албан томилолтоор ажиллах албан хаагчийн төсөв, удирдамжийг батлаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “Ерөнхий нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэг хүлээнэ”, Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ-ын захирлын 2023 оны А/109 дүгээр тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 3 дугаар бүлгийн 3.3-т Албан томилолт олгох журмын 5.1-т “Ажилтан томилолтын хугацаа дуусмагц томилолтоор ажилласан салбар төлөөлөгчийн газар, байгууллагаар томилолтын хуудсыг бөглүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолтоор ажиллах алба хаагчийн томилолтоор ажиллах удирдамж, төсвийг батлан, томилолтын хугацаа дуусмагц ажлын тайланг илтгэх хуудсыг, томилолтын хуудастай хамт авч заасан хугацаанд хааж бөглөх, ажил гүйлгээг гарахаас өмнө анхан шатны баримтыг хянан баталгаажуулж байх

Дээрх шийдвэрүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох
ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
БМ-ийн үлдэгдэлд – дүнтэй материал тайлагнасагдсан	1	196.5			1	196.5	1	196.5				
Дүн	1	196.5	-	-	1	196.5	1	196.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлийн хугацаанд урамшуулал олгосон	1	388.1	1	388.1								
Албан томилолтын удирдамж, төсөв баталдаггүй	1	5,675.5					1	5,675.5				
Дүн	2	6,063.6	1	388.1	-	-	1	5,675.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 19/А/061060.

Сайншанд сум

СТА - 2026/5/НА-СБА-ТӨА.

Төлбөрийг барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захирлын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/29 дүгээр тушаалаар станцын ээлжийн инженер Б.Аззаяад албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан боловч ажилтанд тухайн сарын үр дүнгийн 388,080 төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ-ын захирлын 2022 оны А/141 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар зүйлийн 8.7.2-т “сахилгын шийтгэл ногдуулсан ажилтны тухайн сарын урамшуулал цалинг олгохгүй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон нийт 388,080 (гурван зуун наян найман мянган ная) төгрөгийн урамшууллыг захирал болон ерөнхий нягтлан бодогчоор төлүүлж, Төрийн сан дахь орон нутгийн орлогын 100060000955 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ-ын захирал (О.Төмөрхуяг), ерөнхий нягтлан бодогч (Д.Болортуяа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

АХЛАХ АУДИТОР

М.ДҮҮРЭНЖАРГАЛ



442511058